

## БОГИНО ХУГАЦААНЫ БИЗНЕС (С-3-4)

### ОЛГОХ ХҮРЭЭ:

Зах зээлийн судалгаа, Ажил хэргийн холбоо тогтоох, Зөвлөгөө, Гэрээ байгуулах, Тоног төхөөрөмжийн импорт-экспорттой холбоотой суурилуулах, Засвар үйлчилгээ хийх, Шалгах, ажиллах горимыг сурах болон бусад холбогдох зорилгоор богино хугацаагаар зорчих иргэн.

### БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТУУД

1. Виз мэдүүлгийн маягт (Сүүлийн 6 сарын дотор авахуулсан 3.5x4.5см хэмжээтэй өнгөт зураг)
2. Гадаад паспорт эх хувиар, мөн хуулбар 1 хувь
3. Санхүүгийн чадвар нотлох бичиг баримт
  - Аж ахуй нэгжийн захирал: Байгууллагын татварын тодорхойлолт, аж ахуйн нэгжийн гэрчилгээ
  - Байгууллагын ажилтан: Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, Нийгмийн даатгалын лавлагаа, ажлын газрын тодорхойлолт
  - Бусад : Виз мэдүүлэгчийн нэр дээрх дансны сүүлийн 6 сарын хуулга хураангуй хэлбэрээр (Хамтран эзэмшигч байх боломжгүй)
4. Бизнесийн зорилгыг нотлох бичиг баримт
  - Худалдан авах гэрээ, Үйл ажиллагаа явуулах төлөвлөгөө, В/Л, Экспорт-Импортын лиценз, Татварын баримт, Валют солиулсан бичиг гэх мэт
5. Гэрлэлт бүртгэлийн лавлагаа